



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/551

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор “Хязгаар үгүй ном – Сэтгэлгээний эрх чөлөө” сэдвээр номын баярын арга хэмжээг зохион байгуулахад зориулан 1 000 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Номын баярын арга хэмжээнд зарцуулагдах 1 000 000 төгрөг /нэг сая/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.27-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Б.ДҮГЭРЖАВ

Zax A/551 Ch

02 02484

Аймгийн Засаг даргын 2020 оны  
09 дүгээр сарын 25 -ны өдрийн А/551  
дүгээр захирамжийн хавсралт



**“НОМЫН БАЯР”-ЫН АРГА ХЭМЖЭЭНД ЗОРИУЛАН  
ХУДАЛДАН АВАХ НОМЫН ЖАГСААЛТ**

Д/д	Номын нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Улаан хатан	2	26900	53800
2	Улаан могой	2	27000	54000
3	Малала	2	29900	59800
4	Жэк ма	1	36500	36500
5	Баян аав ядуу аав 2, 3 дугаар боть	4	24500	98000
6	1084 боть	6	28900	173400
7	Санкара	2	35500	71000
8	Галаар наадсан охин	1	29900	29900
9	Зөгийнний үүр бусниулсан охин	1	29900	29900
10	Амийг амиар сольсон охин	1	36900	36900
11	Аалзны торонд орооцолдсон охин	1	29900	29900
12	Луун шивээст охин	1	29900	29900
13	Ану хатан	2	32000	64000
14	Төвдөд эргүүлсэн япон сэлэм	2	27800	55600
15	Сингапурын хөгжлийн нууц	1	39900	39900
16	Хавт хасар	1	37600	37600
17	Спартак	1	32900	32900
18	Сорхугтани	1	32000	32000
19	Учирах тавилан	1	38000	38000
	Нийт	33		1 003 000

-oOo-